



БУЛГАН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/17

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Улсын Их Хурлын 2021 оны 05-р сарын 06-ны өдрийн “Хоршооны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 42.1.5, 43.2.1 дэх заалт, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, Хүнс, хөдөө аж ахуйн газруудын хооронд байгуулсан 2022 оны 09 сарын 19-ны өдрийн 22/133 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г үндэслэн ТУШААХ нь:

1. “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус, тус баталсугай.
2. Хамтран ажиллах гэрээний хавсралтын дагуу судалгаа мэдээллийг хугацаанд нь гаргаж ажиллахыг Мал аж ахуйн алба / албаны дарга М.Жавзандолгор/-т, Үйлдвэх худалдаа үйлчилгээний алба /мэргэжилтэн Д.Мөнхбаасан, Б.Амаржаргал нар/-т даалгасугай.
3. Арга хэмжээнд шаардагдах 5.000.000 /таван сая/ төгрөгийг гаргахыг ерөнхий санхүүч /Л.Отгон/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.АМГАЛАН



Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2022
оны сарын өдрийн тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

ХОРШООНЫ ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ, БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХИЖҮҮЛЭХ
АЖЛЫН ТӨСӨВ

2022.10.10

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт	2	удаа	1000000	2,000,000.00
2	Хулдаасан хэвлэл /4*3/	12	м ²	12000	144,000.00
3	Эх бэлтгэл	1	ш	6000	6,000.00
4	Бусад	1	-	22000	22,000.00
5	Сумдад ажиллах шатахуун	323	литр	3840	1,240,320.00
6	Судалгаа, зохион байгуулсан ажлын тайлан тушаах	1	ш	51680	51,680.00
7	Томилолт	24	хүн/ хоног	64000	1,536,000.00
	Нийт				5,000,000.00